Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж аудитын менежер А.Цээням, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 28-ний өдрийн 1/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Галуут сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга А.Батбаяр, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Б.Анхбаяр нар зурж байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Галуут сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Баянхонгор хайрхнаа шүтэж, хүнээ дээдлэн, уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлж, байгалийн нөөц баялаг, дэд бүтцэдээ тулгуурлан үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалыг хөгжүүлсэн, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин нөхцөл бүрдсэн, хөгжлөөрөө тэргүүлэх сум болно” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх
- Нутгийн удирдлагын чадавх, төр нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг иргэдийн оролцоонд тулгуурлан сайжруулж, хүний хөгжлийг хангах
- Уламжлалт мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалыг хөгжүүлж эдийн засгийн өсөлтийг хангах
- Зам тээвэр харилцаа холбоо, эрчим хүч, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг бүрэн бүрдүүлж, иргэдийн ажиллах, амьдрах ая тухтай орчин нөхцөлийг хангахуйц дэд бүтцийг бий болгох
- Нийтийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл
- Байгаль хамгаалах хөтөлбөр
- Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх
- Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сургалт сурталчилгаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Галуут сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 1,377,546.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,775.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,642.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 342,061,3 мянга, эцсийн үлдэгдэл 495,643,0 мянган төгрөг болж 153,581,7 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах дансанд	342,061,3	495,643,0	153,581,7	44,9

байгаа мөнгөн хөрөнгө

<b>Дүн</b>	342,061,3	495,643,0	153,581,7	<b>44,9</b>
------------	-----------	-----------	-----------	-------------

Эх сурвалж: Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 495,643,0 мянган төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн 63,208,7 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 182,238,7 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 39,858,9 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 210,336,3 мянган төгрөг байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 406,477,5 мянга, эцсийн үлдэгдэл 231,767,0 мянган төгрөг болж 174,710,5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	613.2	523.7	(89.5)
Татаас санхүүжилтын авлага	284.420.5	-	(0)
Байгууллагаас авах авлага	1712.2	66.2	(1645.9)
Хувь хүмүүсээс авах авлага			-
Хувь хүмүүст олгосон зээл	119,731,6	231,177.1	(111,445.5)
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл			-
<b>Дүн</b>	<b>406.477.5</b>	<b>231.767.0</b>	<b>-113,180,9</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 74,5 хувь буюу 231,177.1 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 10,6 хувь буюу 246.2 мянган төгрөг ЗДТГ-ын авлага, 14,9 хувь буюу 343,6 мянган төгрөг нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын авлага байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	197,7	246,2	48,5	19,6
ИТХ	43,7	343,6	300,0	32,2
Бага сургууль	34,4	0	(34,4)	0,0
ЭМТ	286,301,4		(286.301.4)	0,0
СХС	119,731,6	231,177,1	111445,5	48,2
Цэцэрлэг	72,8		(72.8)	0,0
ЕБС	95,7		(95.7)	0,0
ОНХСан	0		0	0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>406,477,5</b>	<b>231,767,0</b>	<b>(174.710.5)</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 119.731.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд зээл 154,000.0 олгосон бөгөөд 42,554,5 мянган төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст 231,177,1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 419,936,2 мянга, эцсийн үлдэгдэл 126,265,9 төгрөг болж, 293,670,3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	13,082,2		(13,082.2)
Эм боох материал	6,863,7		(6,863.7)
Бичиг хэргийн материал	8,145,3	5,155,8	(2,989,5)
Аж ахуйн материал	251,189,3	17,176,1	(234,013,2)
Сэлбэг хэрэгсэл	21,0	4,388.0	4,367.0
Түлш, шатах тослох материал	475,0		(475.0)
Барилгын засварын материал	15,703.0		(15,703)
Хүнсний материал	3,143.0		(3,143.0)
Бусад хангамжийн материал	111,311.0	89,545,9	21,765,1
Мал амьтад	10,000.0	10,000.0	0
Нөөцийн бараа			
<b>Дүн</b>	<b>419,936,2</b>	<b>126,265,9</b>	<b>(293,670,3)</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 126,265.9 мянган төгрөг болж өмнөх оноос 293,670.3 мянган төгрөгөөр буурсан Ерөнхий боловсролын сургууль, Бага сургууль, Эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв нь улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой тухайн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	1,356,4	7,515,6	6,159,2	81.9
ЗДТГ	115,831,4	118,750,3	2,918,9	18.1
Соёл	10,389,5		(10,389,5)	-
ЭМТ	42,564,4		(42,564,4)	-
Бага сургууль	41,868,5	00	(41,868,5)	0
ЕБС	136,420,8		(136,420.8)	-
Цэцэрлэг	71,505,0		(71,505.0)	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>419,936,2</b>	<b>126,265,9</b>	<b>(293,670,3)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 164,454,4 мянган төгрөгийн бараа материалын 154,781.9 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 9,672.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 458,124,7 мянган төгрөгийн 302,748,3 мянган төгрөг буюу 66.0 хувь нь шилжүүлсэн бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	164,454,4	Хасагдсан	458,124,7
Худалдан авсан	154,781,9	Худалдсан, зарцуулсан	155,376,3
Хандиваар		Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	
Шилжүүлсэн авсан	9,672.5	шилжүүлсэн	302,748,3
бусад		бусад	

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,910,619,5 мянга, эцсийн үлдэгдэл 6,365,161.7 мянган төгрөг болж 2,545,457.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	------------------------	-----------------

**Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	<b>8,790,266.4</b>	<b>6,345,353.7</b>	<b>(2,444,912.7)</b>	<b>0.4</b>
Барилга байгууламж, орон сууц	5,290,283.4	1,405,558.9	(3,884,724.5)	2.7
Тээврийн хэрэгсэл	247,004.8	40,770.1	(206,234.7)	5
Машин тоног төхөөрөмж	778,486.4	81,823.0	(696,663.4)	8.5
Тавилга эд хогшил	356,600.3	14,214.2	(342,386.0)	24.0
Зам гүүрийн байгууламж	1,775,753.8	4,695,180.4	2,939,426.6	62.6
Түүх соёлын дурсгалт зүйл	384.6	00	(384.6)	0.0
Дуусаагүй барилга байгууламж	00	00	00	0.0
Номын фонд	29,108.7	00	(29,108.7)	0.0
Бусад үндсэн хөрөнгө	312,644.2	107,806.8	(204,237.4)	1.9
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>120,353.1</b>	<b>19,808.0</b>	<b>(100,545.1)</b>	<b>4</b>
Программ хангамж	2,137.1	00	(2,137.1)	0.0
Бусад биет бус хөрөнгө	118,216.0	19,808.0	(98,408.0)	0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8,910,619.5</b>	<b>6,365,161.7</b>	<b>2,545,457.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, Бага сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр 4,514,980.2 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	54,258.2	36,993.1	-17,265.1	46.6
ЗДТГ	4,341,381.1	6,328,168.6	1,983,787.6	53.4
Соёл	184,814.5		-184,814.5	0.0
ЕБС	2,035,158.9		-2,035,158.9	0.0
Цэцэрлэг	815,499.9		-815,499.9	0.0
Эмнэлэг	1,218,964.0		-1,218,964.0	0.0
Бага сургууль	260,542.9		-260,542.9	0.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8,910,619.5</b>	<b>6,365,161.7</b>	<b>-2,545,457.8</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 3,037,085.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 98.8 хувь буюу 3,002,937.4 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	<b>3,037,085.3</b>	Хасагдсан	4,521,920.1
Худалдан авсан	34,147.9	Худалдсан	
Хандиваар	0.00	Акталсан	6,940.0
Шилжүүлэн авсан	0,0	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	4,514,980.1
бусад	3,002,937.4	Бусад	

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### **3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4,775,3 мянга, эцсийн үлдэгдэл 16,077,5 өглөгийн үлдэгдэлтэй бөгөөд 11,302.2 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	<b>4,775.3</b>	<b>16,077.5</b>	<b>11,302.2</b>	<b>100.0</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	407.9	479.9	72.0	15.0
Бараа үйлчилгээний	328.3	0.0	-	10.9

зардлын өглөг			328.3	
Байгууллагад төлөх өглөг	4,039.0	15,597.6	11,558.6	74.1
Хувь хүмүүст өгөх өглөг			-	-
<b>Дүн</b>	<b>4,775.3</b>	<b>16,077.5</b>	<b>11,302.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацааны эцэст богино хугацаат өр төлбөрийн 16,077.5 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	0	479.9	479.9	
ЗДТГ		10.0	10.0	
Соёлын төв	90.0		(90.0)	
ЕБС			-	-
ЭМТ	580.0		(580.0)	
ОНХС	4,000.0	15,587.6	11,587.6	74.3
Цэцэрлэг	105.3		(105.3)	
СХСан			-	-
<b>ДҮН</b>	<b>4,775.3</b>	<b>16,077.5</b>	<b>11,302.2</b>	<b>70.3</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,461,696.0 мянга, эцсийн үлдэгдэл 1,284,112.3 мянган төгрөг болж, 3,282,954.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,284,112.3	1,284,112.3	(0.0)	
Өмч: - төрйн			-	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,986,740.8</b>	<b>5,710,096.7</b>	<b>2,723,355.9</b>	<b>47.6</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,972,967.6	208,550.7	(2,737,129.1)	131.2
<b>Дүн</b>	<b>8,421,404.5</b>	<b>7,202,759.8</b>	<b>2,218,644.7</b>	<b>17.0</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,218,644.7 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Бага сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр тухайн тайлант нэгтгэгдээгүйтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2021.12.17-ний өдрийн хуралдаанаар 4/05 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 482,300.0 мянга, хүү торгуулийн орлогыг 20,000.0 мянга, нийт 502,300.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	482,300.0	683,610.5	(201,310.5)	141.7
ЦХТА рлого /суутган/	114,000.0	154,342.4	(40,342.4)	135.3
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2,000.0	1,158.8	841.2	57.9
Бууны татвар	3,800.0	4,080.0	(280)	107.3
ИОТХ	30,000.0	23,228.6	6,771.4	77.4
Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	13,056.3	(11,556.3)	870.4
Хадгаламжийн хүүгийн орлого	36,000.0	30,790.5	5,209.5	85.5
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	4,000.0	2,050.0	1,950.0	51.2
Малын тоо толгойн албан татвар	100,000.0	83,362.8	16,637.2	83.3
Газрын төлбөр	45,000.0	58,971.2	(13,971.2)	131.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,000.0	14,378.0	(2,378.0)	119.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	132,000.0	297,148.0	(165,148.7)	225.1
ТТАМАТөлбөр	2,000.0	696.0	1,304.0	34.8
Ахуй хэрэглээний ус ашигласны төлбөр	-	347.2	(347.2)	
2.Татварын бус орлого	20,000.0	6,190.0	13,810.0	309
2.1.Хүү торгуулийн орлого	20,000.0	6,190.0	13,810.0	30.9
<b>Нийт дүн</b>	<b>502,300.0</b>	<b>689,979.7</b>	<b>(201,310.5)</b>	<b>171.9</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 171.9 хувь буюу 201,310,5.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 40,342.4 мянга, бууны албан татвар 280,0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 11,556,3 мянга, газрын төлбөр 13,971.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2,378.0 мянга, ахуйн хэрэглээний ус ашигласны төлбөр 347.2 мянга, ан амьтаны нөөц ашигласны төлбөр 165,148.7 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна. Харин иргэний орлого тодорхойлох татвар 6,771.4 мянга, Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого 1,950.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 5,209.5 мянга, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 841.2 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1,304.0 мянга, малын тоо толгойн албан татвар 16,637.2 мянга, торгуулийн орлого 13,810.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлого төлөвлөсөн ч биелээгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 74,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 59,535.3 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,711,204.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, 1,377,546.3 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас, 1,178,842,7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 198,703.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Галуут сумын Засаг дарга	1,560,798.4	1,244,642.1	316,156.3	79.4

2	<b>70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага</b>	<b>105,713.0</b>	<b>89,111.0</b>	<b>1,521.8</b>	<b>84.2</b>
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	44,693.0	43,793.2	25.0	98.1
4	<b>70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>458,495.4</b>	<b>361,233.7</b>	<b>2,950.9</b>	<b>78.7</b>
5	80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	121,777.6	90,890.9		74.6
6	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,000.0	0		0
7	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	25,813.3	25,813.0	0.3	99.9
8	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	57,760.0	57,756.4	3.5	99.9
9	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	0			0
10	82212 хур хог хаягдал, орчны бохирдол	12000.0	8,141.9	3,858.1	67.8
11	Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа	0			
12	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	32,246.9	32,114.7	132.1	99.5
13	71702 Соёл урлаг	68,188.5	68,096.2	92.2	99.8
14	71801 Сургуулийн өмнөх боловсрол	55,962.3	5,0030.8	5,931.5	89.4
15	71802 Ерөнхий боловсрол	173,231.5	172,711.3	1,202.1	99.6
16	71802 Бага сургууль	27,746.4	24,152.1	3,594.2	87.0
17	70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт	87,346.7	52,836.1	34,510.6	60.4
18	83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	162,984.5	140,967.4	22,017.1	86.4
19	73402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр	30,558.7			
20	83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	100,000.0	4,900.0	95,100.0	3.0
21	83406 ОНХС -бусад	33,015.2	0		
22	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	209,244.7	154,921.1	54,323.5	74.0
	<b>Нийт дүн</b>	<b>1,711,204.4</b>	<b>1,377,546.3</b>	<b>333,657.8</b>	<b>80.5</b>

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.17-ний өдрийн 4/05 дугаар тогтоолоор нийт 1,817,834.5 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	75,024.0	154,104.0	-79,080.0
Засаг даргын Тамгын газар	373,799.8	580,618.0	-206,818.2
Сургууль	229,838.6	229,838.6	0.0
Цэцэрлэг	84,402.3	84,402.3	0.0
Эрүүл мэндийн төв	32,246.9	32,246.9	0.0
Соёлын төв	65,749.1	65,749.1	0.0
Сум хөгжүүлэх сан	0	209,524.7	-209,524.7
Орон нутгийн хөгжлийн сан	0	413,905.1	-413,905.1
<b>Нийт дүн</b>	<b>866,376.8</b>	<b>1,329,290.9</b>	<b>909,328.0</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.17-ний өдрийн 4/05 дугаар тогтоолоор анх 1,817,834.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2022.06.16-ны өдрийн 7/02 дугаар тогтоолоор 106,630.1 мянган төгрөгөөр бууруулж 1,711,204.1 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 226,558.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 528,856.1 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 502,300.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 40,452.4 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 339,037.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, сум хөгжүүлэх сангийн орлогоос 74,000.0 төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 528,856.1 мянга, орон нутгийн орлогоос 572,914.6 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 225,312.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 89,345.8 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 76.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 63,208.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	580,273.0	543,912.1	36,360.9	93.7	36,360.9
ИТХ	150,406.0	132,904.1	17,501.9	88.3	17,501.9
Соёлын төв	68,188.5	68,096.2	92.3	99.8	92.3
Сум хөгжүүлэх сан	209,244.7	154,921.2	54,323.5	74.0	54,323.5
Сургууль	173,231.5	172,711.3	519.9	99.6	519.9
Бага сургууль	27,746.4	24,152.1	3,594.3	87.0	3,594.3
Цэцэрлэг	55,962.3	50,030.8	5,931.5	89.4	5,931.5
ЭМТ	32,246.9	32,114.7	132.2	99.5	132.2
ОНХС	413,905.1	198,703.5	215,201.6	48.0	215,201.6
<b>Нийт дүн</b>	<b>1,711,204.4</b>	<b>1,377,546.3</b>	<b>333,657.8</b>	<b>80.5</b>	<b>333,657.8</b>

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,377,546.3 мянган төгрөг буюу 80.5 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 36,360.9 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 17,501.9 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөсөн ажлууд хийгдээгүйгээс зардлыг 215,201.6 мянга, сум хөгжүүлэх сангаас зээл иргэнд 50 хувиар олгосонтой холбоотой 54,323.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 16,469.3 мянга, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 1,300.0, мянга, Аймгийн засаг даргын нөөцөөс 6,154.0 мянга, Аймгийн статистикийн хэлтсээс 2,729.0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,286.3 мянган

төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 16,469.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	НИЙТ
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,300.0	15,169.3	16,469.3
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.0	2,729.0	4,029.0
ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,154.0	6,154.0
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6,286.3	6,286.3
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	1,300.0	15,169.3	16,469.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1300.0	15,169.3	16,469.3
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	0	0
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Галуут сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Галуут сумын Засаг дарга нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ... зорилтын хүрээнд ... арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ... хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Сумын Засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 50.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,711,204.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,377,546.3 мянган төгрөгийг зарцуулж, 81.4 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 502,300.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 683,610.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 141,7 хувь буюу 201,310.5 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 7 нэр төрлийн 46,523.3 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 5 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Галуут сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохио	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарла лттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1		1						
ИТХурал	1	1		1						
ОНХС	1	1		1						
СХС	1	1		1						
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>4</b>		<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>			<b>0</b>

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 168,234.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17,265.9 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 105,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 46,969.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ХХС	1	17,265.9	1	17,265.9						
ОНХСан							1	105,000.0	1	45,969.0
СТА зөрчлийн дүн	3	168,234.9	1	17,265.9			1	105,000.0	1	45,969.0
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ										
НХСан										
Нийцлийн аудитын дүн										
Нийт дүн	3	168,234.9	1	17,265.9			1	105,000.0	1	45,969.0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 130 мэдээллийг хугацаанд нь, 21 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	12	12	10		2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	88		
4	Сар бүр	5	60	43	17	
5	Тухай бүр	6	72	66	6	
	Нийт	28	155	130	23	2

Эх сурвалж. Галуут сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Галуут сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илрээгүй байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8 алдаа, зөрчил илэрснээс 4 төлбөрийн акт алдаа, зөрчил давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 08-ний өдрийн 2/42 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	4	4	4	4			
Зөвлөмж	4	0	4	0			100.0
Нийт	4	0	4	0			100.0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй байх 33,345.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 33,345.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч, зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлээ.

##### 4.1.1 Албан шаардлага

Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 116,707.8 мянган төгрөг төвлөрүүлэхээр ногдуулалт хийсэн байхад 83,362.8 мянган төгрөг төвлөрүүлж 33,345.0 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Малын тоо толгойн албан татварын 33,345.0 мянган төгрөгийн дутуу төвлөрсөн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

##### 4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ

Илрүүлэлт: Галуут сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 168,234.9 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн харьяанд нэгтгэгддэг төсвийн шууд захирагчдын Нягтлан бодох бүртгэлийн тайлагнал, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

###### 2. БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ

Илрүүлэлт: Галуут сумын Засаг даргын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ-аар батлуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргахдаа, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Галуут сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
2022			БНА-2023/8/НА-СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Галуут сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:					
1	Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 116,707.8 мянган төгрөг төвлөрүүлэхээр ногдуулалт хийсэн байхад 83,362.8 мянган төгрөг төвлөрүүлж 33,345.0 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.	33,345.0	Албан шаардлага өгөв.	Төсвийн захирагч, Санхүүгийн албан дарга	Г.Доржбат, Б.Анхбаяр
2	Галуут сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 168,234.9 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна.	0	Зөвлөмж өгөв.	Төсвийн захирагч, Санхүүгийн албан дарга	Г.Доржбат, Б.Анхбаяр
3	Галуут сумын Засаг даргын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг сумын ИТХ-аар батлуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна.	0	Зөвлөмж өгөв.	Төсвийн захирагч, Санхүүгийн албан дарга	Г.Доржбат, Б.Анхбаяр
<b>ДҮН</b>		33,985.3			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_